



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 24 өдөр

Дугаар А/189

Мөрөн сум

Арга хэмжээний жагсаалт,
төсөвт өртөг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.3, 41.2.6, 65 дугаар зүйлийн 65.1.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2022 оны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний 2.5.5 –д туссан “Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих төвд тоног төхөөрөмж худалдан авах /Цагааннуур сум/” арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын жагсаалт, төсөвт өртөгийг нэгдүгээр хавсралтаар, 2.5.4–д туссан “Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих төвд тоног төхөөрөмж худалдан авах /Мөрөн сум/” арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын жагсаалт, төсөвт өртөгийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Батлагдсан арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг (Орон нутгийн өмчийн газар Б.Должинсорогдог)-т даалгасугай.


3. Төлөвлөгдсөн бараа, ажил, үйлчилгээг үр дүнтэй зохион байгуулж, хэрэгжилтийг тухай бүр тооцож, хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Оюунтуяа), Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Базар)-т тус тус үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Аймгийн Засаг даргын 2023 оны 04 дүгээр
сарын 24 өдрийн А/121 дугаар захирамжийн
нэгдүгээр хавсралт




ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ЖАГСААЛТ, ТӨСӨВТ ӨРТӨГ
/ЦАГААННУУР СУМ/

№	Зардлын утга	Нийт үнэ
1	Хүнсний тоног төхөөрөмж	85.700.000 (Наян таван сая долоон зуун мянган төгрөг)
2	Ахуйн үйлчилгээний тоног төхөөрөмж	76.100.000 (Далан зургаан сая нэг зуун мянган төгрөг)
3	Өрхийн үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж	18.200.000 (Арван найман сая хоёр зуун мянган төгрөг)
	НИЙТ	180.000.000 (Нэг зуун наян сая төгрөг)

___Ооо___

Аймгийн Засаг даргын 2023 оны 04 дүгээр
сарын 24. өдрийн А/181 дугаар захирамжийн
хоёрдугаар хавсралт



ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ЖАГСААЛТ, ТӨСӨВТ ӨРТӨГ
/МӨРӨН СУМ/

№	Зардлын утга	Нийт үнэ
1	Ноос, арьсан урлал хийхэд ашиглах тоног төхөөрөмж	124.000.000 (Нэг зуун хорин дөрвөн сая төгрөг)
2	Сургалт /Чадамжийн гэрчилгээтэй/	16.000.000 (Арван зургаан сая төгрөг)
3	Маркетинг зөвлөх үйлчилгээ	40.000.000 (Дөчин сая төгрөг)
	Нийт	180.000.000 (Нэг зуун наян сая төгрөг)

_____оОо_____